

БҮС НУТАГ ТҮҮНИЙ ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ОПЕРАТИВЫН БАЙГУУЛАМЖ



ХИЛ СУДЛАЛ

Н.Наранжамц

Удирдлагын академийн хилийн албаны удирдлага-стратегийн тэнхимийн ахлах багш, доктор, профессор (Ph.D), хурандаа

Naranjamts N.

Senior Lecturer, Doctor, Professor (Ph.D.), Colonel, Department of Management and Strategy of the Border Service of the Academy of Management

Г.Содбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн суралцагч, хошууч

Sodbayar G.

Student, Master's student, Major of the Management Academy of the University of Internal Affairs

Ц.Баяндалай

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн суралцагч, хошууч

Bayandalai Ts.

Student, Master's student, Major of the Management Academy of the University of Internal Affairs

*Хариуцлагатай зохиогч: Sodoo8088@gmail.com

Хураангуй: Бүс нутаг түүний хилийн аюулгүй байдал нь дэлхий дахинд бүс нутаг, улсын хил гэдэг ойлголтыг тусгаар тогтнолын баталгаа, газар нутгийн хаяа хязгаарыг тодорхойлогч гэж үздэг бол, бүс нутагт гарах өөрчлөлт, хилийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл, хилийн аюулгүй байдлыг хангах, улсын хилийг хамгаалах, хил хамгаалалтын оперативын байгууламжийг нэмэгдүүлэх, зэрэг асуудлуудын талаарх судалгааны үр дүнг танилцуулахыг зорилоо.

Abstract: The region and its border security. While the concept of regional and national borders is considered a guarantee of independence and a determinant of territorial boundaries around the world, the aim is to present the results of research on changes in the region, factors affecting border security, ensuring border security, protecting the state border, and increasing operational facilities for border protection.

Түлхүүр үгс: Бүс нутаг, хилийн аюулгүй байдал, оператив, байгууламж, тусгаар тогтнол, улсын хил.

Keywords: Region, border security, operational, facilities, independence, state border.

Удиртгал

Хил хязгаарын тухай ойлголт нь хүн төхөлтөн үүссэн цагаас бий болсон гэж үздэг бөгөөд энэ нь хүй нэгдлийн үеэс өнөөг хүртэлх хугацааг хамарч байгаа бөгөөд эртний хүн сүрэг нь идэх хоол хүнс, амьтан ургамлыг эрж хайх, олж эзэмших явцдаа байгалийн хил хязгаар хэмээх ойлголтыг бий болгож, өөр бусад хүн сүргээс олж эзэмшсэн хоол хүнс, байгалийн бүтээгдэхүүнээ хамгаалж ирсэн байна. Хүн төрөлхтөний хөжлийн явцад амьдрах орчин, нөхцөл өөрчлөгдөж, хүн сүргээс ухамсарт хүн бий болж, тэдний хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэхтэй уялдан хэлбэр хэмжээ, их багын тухай ойлголт бий болж,

энэхүү ойлголтыг хэмжих хэмжүүрийн нэгжийн хязгаар буюу “Хил” хэмээх ухагдахуун бий болсон гэж судлаачид үздэг байна. Өөрөөр хэлбэл “Хил гэдэг нь аливаа юмс зүйлийн хэлбэр хэмжээг тодорхойлогч ухагдахуун” юм (Наранжамц. Н, 2017).

Үндсэн хэсэг;

Монгол Улсын нутаг дэвсгэрийн зах хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил (цаашид “улсын хил” гэх) гэнэ. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна (УИХ, 2017).



Үүнээс үзвэл хил нь хязгаарлагч, хязгаарын тухай ойлголт болох бөгөөд энэхүү ойлголтыг улс үндэстнүүд газар нутгийн хязгаарыг тодорхойлж буй утгаар нь өргөн хэрэглэж заншсан байна.

Тусгаар улсыг тодорхойлогч хэд хэдэн хүчин зүйлс байдаг байна. Үүнд:

-Өөрийн гэсэн газар нутагтай, хүн амтай, хил соёлтой тусгаар тогтнолоо дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд тунхаглан зарласан байх явдал юм.

Тусгаар тогтносон тусгаар улсыг тодорхойлогч чухал хүчин зүйлүүдийн нэг болох газар нутаг нь тодорхойлон тогтоогдож тэмдэглэгдсэн хил хязгаартай байх бөгөөд газар нутгийн үндсэн баталгаа нь өөрийн гэсэн улсын хилтэй, энэхүү хил хязгаараа зэргэлдээ улс орнуудаараа хүлээн зөвшөөрүүлж, гэрээ хэлэлцээрээр баталгаажуулан, хууль тогтоомжоор зохицуулсан байх явдлаар хангагдана.

Дэлхий дахинд улсын хил гэдэг ойлголтыг тусгаар нутгийн хаяа хязгаарыг тодорхойлогч гэж үзэн “Улсын хил” гэсэн нийтээр хүлээн зөвшөөрсөн ухагдахуун бий болгон хэрэглэж нэгэнт заншсан болно.

Улсын хилийг:

-Газрын хил;

-Усан хил;

-Агаарын хил;

-газрын хэвлийн хил гэж ангилан авч үздэг бөгөөд даяаршлын өнөөгийн үед улсын хилийн талаарх ойлголт улам бүр өргөсч:

-Нийтлэг хил хязгаар;

-Ашиг сонирхлын хил хязгаар;

-Газар нутгаас ангид хил хязгаар хэмээх шинэ ойлголтууд нэгэнт бий болоод байна (Наранжамц.Н, 2017).

Түүнчлэн улс гүрнүүдийн оршин байгаа газар нутаг нь:

Тусгаар тогтнолын баталгаа эсвэл тусгаар тогтнохын үндэс болдог;

Мөнхөд оршин байх, эзэмшсэн байх нь улс бүрийн язгуур ашиг сонирхол нь болдог;

Хүн амын амьдран байх үндэс, баялгийн эх сурвалж болдог төлийгүй үйлдвэрлэл, үйлчилгээ, хууль ёс сахих эх талбар, өөрийнхөө доорх баялаг

нууцлагаараа бусдын ашиг сонирхлыг татаж байдаг юутай ч зүйрлэшгүй үнэт баялаг юм. Дэлхийн улс гүрнүүд аюулгүй байдлаа хангах үндэсний бодлого стратегиа бий болгох, хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарч, ихэнхдээ дэлхий дахин, бүс нутгийн аюулгүй байдлыг чухалчлан үзэж байна (Наранжамц.Н, 2017).

Цэргийн эрдэмтэд, онолчид ертөнцийн орон зайг геостратегийн орон зайгаар нь дараах бүсүүдэд хуваан авч үзэж байна. Үүнд:

-Тивийн бүс;

-Эх газрын бүс;

-Далайн бүс;

-Стратегийн орон зайн бүс;

Сансарын стратегийн бүс гэх мэт. Эдгээрээс стратегийн бүсийг тив дэлхийн газар нутгийн хэсэг эсвэл тухайн газар нутгийг бүхэлд нь ойролцоо байх эдийн засгийн бүс, агаарын орон зайг хамтатган авч үзэж аливаа улсын цэрэг эдийн засгийн болзошгүй аюулаас хамгаалах орчин гэж тодорхойлсон байна. Жишээ нь: ОХУ, Европын болон Евроазийн газар нутаг, Европын улсууд болон: Азербайжан, Армени, Гүрж, Кипр, Ливан, Сири болон Турк тэдгээрт хамаарах Атлант, Каспин тэнгисийн бүс нутгийн болон агаарын орон зайг оруулан дээрх чиглэл дэх гадаад тэнгисийн хилийг хүртэлх орон зайг багтаасан хуурай газар, тэнгис, далайн уудмыг өөрийн улсын Европ дахь стратегийн бүс гэж авч үздэг байна (Наранжамц.Н, 2012, 2024).

Монгол Улсын хилийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.2-д Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байхыг хэлнэ (УИХ, 2017).

Монгол Улсын хувьд бүс, бүс нутаг, стратегийн болон оперативын орон зайгаа тодорхойлох зайлшгүй шаардлагатай бөгөөд өнөөдрийн байдлаар төв болон дундад, зүүн хойд, зүүн өмнөд Ази, Европын Орос дахь газар нутаг, Казакстан, Хятадын газар нутаг бүхэлдээ, Энэтхэгийн болон Номхон далай, Солонгосын хойгийг багтаасан орон зайг өөрийн улсын аюулгүй



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠬᠤᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ
MONGOLIAN STATE COURT

байдлын бүс, бүс нутаг гэж авч үзэж болох юм (Наранжамц.Н, 2012, 2024).

Өнөөдөр дэлхийн газар нутаг үндсэндээ их гүрнүүдийн хяналтад хуваагдаж, тухайн улсын аюулгүй байдалд нөлөөлөх аливаа сөрөг хүчин зүйлийг даван туулах, арилгахад чиглэсэн цэрэг-улс төр, худалдаа эдийн засаг болон бусад бодлого, үйл ажиллагааг бүс нутгийн хэмжээнд авч хэрэгжүүлж байгаа нь нэгэнт тодорхой билээ. Уламжлалт их гүрнүүд болон хүн ам, газар нутаг, хөгжлөөрөө тэргүүлэгч улсууд дэлхий дахинд өөр өөрийн бодлого (улс төр, эдийн засаг, хууль, худалдаа, далай тэнгисийн баялаг, ашигт малтмал, газрын тосны нөөц гэх мэт хөгжилд түлхэц өгөхүйц эх сурвалжуудыг эзэмших, ашиглах, хяналтадаа байлгах)-ыг тодорхойлон өрсөлдөж байгаа нь нууц биш бөгөөд энэхүү сөргөлдөөн тэмцлийн явцад тухайн бүс нутагт оршиж байгаа бага, дунд буурай улс орнуудын язгуур эрх ашиг, аюулгүй байдал хөндөгдөж буй улс орнууд оршин байх, аюулгүй байдлаа хангахад онцгой анхаарах боллоо. Өөрөөр хэлбэл тухайн улсын аюулгүй байдал нь бүс нутгийн аюулгүй байдал болон дэлхий дахин бүс нутгийн глобал хямрал (дэлхийн дулаарал, эдийн засгийн хямрал, байгаль-экологи, нөөцийн хомсдол гэм мэт)-аас шууд ба шууд бус хамааралтай болох нь нэгэнт тодорхой болж байна. Монгол улс хэдийгээр далайд гарцгүй, эх газрын улс боловч дэлхий дахин болон бүс нутагт нөлөө бүхий хүчирхэг их гүрнүүдтэй хил залган оршдог, аюулгүй байдал нь дээр дурдсан улсуудаас шууд хамааралтай төдийгүй бүс нутагт дээрх улсуудын нөлөөгөөр тогтвортой байх, тогтворгүй байх нь шууд шалтгаалах эмзэг орчинд оршин тогтнож байна (Наранжамц.Н, 2024).

Дэлхий дахинд цэрэг улс төрийн нөхцөл байдал төдийлөн таатай бус, бүс нутаг, улс хоорондын зөрчил тэмцэл үргэлжлэн, зарим тохиолдолд бүхэл бүтэн тив, улсыг хамарсан (хувсгал) тэмцэл гарч, дээрх бүс нутаг, улс оронд тогтворгүй байдлыг бий болгож, улмаар дэлхий дахины цэрэг, улс төр, нийгэм эдийн засагт

нөлөөлөхүйцээр даамжрах хандлага бий болж байна.

Бүс нутгийн аюулгүй байдлын орчинд таагүй өөрчлөлт гарах, эдийн засаг, хүмүүнлэгийн хямрал нүүрлэх, улмаар хөрш орнуудын дотоод улс төрийн байдал хурцдах, үндэсний эв нэгдэл, нэгдмэл байдалд нь заналхийлэх хүчин зүйлс их биш ч, үгүйсгэж боломжгүй байна. Үйл явцын ийм таагүй өрнөлийн үед зэвсэгт бүлэглэлүүд салан тусгаарлагчид, олон улсын террористууд, үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлүүдийн зохион байгуулалттай үйл ажиллагаа идэвхижиж болзошгүй.

Нөгөө талаар монгол улсын хилийн халдашгүй дархан байдлыг үгүйсгэж, улсын хил зөрчин гэмт хэрэг үйлддэг, хил орчмын нутаг дэвсгэрт амьдрагч иргэдийн амь нас, аюулгүй байдалд заналхийлдэг, улсын хилээр хориглосон бараа материал, зэвсэг, галт хэрэгсэл хил нэвтрүүлдэг, зохион байгуулалттайгаар ноос ноолуур, ангийн үс, эд эрхтэн, архелогийн олдвор, үнэт металл, ховор эдлэлийг хууль бусаар хил нэвтрүүлэн худалдсан гэх мэт уламжлалт зөрчлүүд, сүүлийн үед хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах бодис хил давуулах гэмт хэрэг илэрхий даамжрах хандлагатай болж, бүс нутагт энэ төрлийн гэмт хэрэг идэвхжиж, манай улс дээрх гэмт хэргийн сүлжээнд бүртгэгдэж, үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлээс манай улсын иргэдийг болон хилийн хяналт шалгалтын сайнгүй нөхцөл байдлыг гэмт үйлдэлдээ ашиглах боллоо. Түүнчлэн улсынхаа хилийг эцэслэн тодорхойлж, тогтоогоогүйн улмаас хилийн асуудлаарх маргаан нь даамжран бүс нутгийн зарим улсуудын хооронд улс төр, дипломатын аргаар зохицуулахад хүндрэлтэй нөхцөл байдлууд бий болоход хүргэж байна. Бүс нутагт салан тусгаарлах үзэл, ажиллагаа идэвхжиж, үргэлжилсээр байгаа нь томоохон улсуудын улс төр, цэрэг, эдийн засгийн хүчийг туйлдуулах, залхаахад хүргэж, улмаар салан тусгаарлагчидтай хүчний тэмцэл явуулахад хүргэж байгаа нь дүрвэгсэд, нууцаар хил нэвтрэгсдийн тоог өсгөхөд хүргэж болзошгүй болно. Бүс нутаг дахь таагүй

нөхцөл байдал нь тухайн бүс нутаг дахь улс орнуудын аюулгүй байдал, түүний дотор улсын хил, хилийн орон зайд улс үндэстний аюулгүй байдалд нөлөөлөх тодорхой сөрөг хүчин зүйлүүдийг (нөхцлийг) бий болгодог байна. Дэлхийн улсуудын авч үзэж байгаагаар дурьдсан нөхцөл байдлууд нь тухайн улсын хилийн аюулгүй байдалд нөлөөлөх, зайлшгүй анхаарвал зохих дараах сөрөг хүчин зүйлүүдийг бий болгодог гэж үздэг байна (Наранжамц.Н, 2017). Үүнд:

-Хөрш улсуудын тусгай албадын явуулж буй тагнуул-сөрөг ажиллагаа;

-Тухайн улсыг өөрийн геополитикийн ашиг сонирхлын хүрээнээс гаргах зорилгоор бусад бүлэг улсуудын зүгээс тодорхой бүс нутагт өөрсдийн нөлөөллийг нэмэгдүүлэх хүчин чармайлт тавьж буй байдал болон найрсаг дотно харилцагч улсуудтай явуулах хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлөх оролдлого;

-Хил залгаа улсуудын үндсэрхэг үзэлтэй байгууллагуудын зүгээс өөрийн төр засгаас тухайн улсад алдагдсан гэх газар нутгаа эргүүлэн авах гэх мэт элдэв шаардлага үйл ажиллагаа;

-Хилийн шугамын явалт өөрчлөгдсөнөөс үүдэлтэй нутаг дэвсгэрийн харъяаллын талаарх санал зөрөлдөөн;

-Хил орчмын нутаг дэвсгэр дэх нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдлын хүндрэл;

-Олон улсын гэмт хэргийн бүлэглэлүүд хууль бусаар дүрвэгсдийг тухайн оронд оруулах, гуравдагч улсад гаргах болон түүхий эд, үнэт зүйлс, материалын нөөц, зэвсэг галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх оролдлого;

-Хил залгаа улстай хилийн шугам тодорхой тогтоогдоогүй байдал, цэрэг улс төрийн цагийн байдлын хурцдал, хил орчим дахь хууль бус бүлэглэлийн үйл ажиллагаа, улс орны дотоод зөрчлийг зохицуулах үйл явцын хүндрэлтэй холбоотойгоор хилийн зарим хэсгийн цагийн байдлын тогтворгүйжилт;

-Хил хамгаалах байгууллага, хилчдийн эсрэг тухайлбал, улсын хилийн шалган нэвтрүүлэх боомт газруудад гэмт

этгээд, алан хядагчдын зүгээс явуулж буй хууль бус үйл ажиллагаа;

Мэдээллийн сөргөлдөөний идэвхжил, улс үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлүүд төр засгийн эрх мэдлийг бууруулах, хил орчмын оршин суугч, цэргийн алба хаагчид, тэдний гэр бүлийн эсрэг хууль бус үйлдэл хийхэд турхирах, заналхийлэх замаар сэтгэл зүй, мэдээллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж явуулах зэрэг болно.

Орчин үед дэлхийн улсуудын олон улсын тавцан дээрх байр суурь нь юуны түрүүнд байгалийн баялаг, технологи, мэдээллийн нөөц, тэдгээрийг борлуулах зах зээлийг эзэмших зорилго бүхий өрсөлдөх чадвараар хэмжигдэж байна.

Улсын хил, хилийн аюулгүй байдалд учруулж болох аюул заналыг бүхэлд нь:

-Улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, цэргийн, хүн амын, байгаль экологийн аюулгүй байдалтай шууд холбоотой гэж үздэг тул улсын хил, хилийн орон зайд улсын хил хамгаалалтын найдвартай тогтолцоо бий болгохыг шаардаж байдаг.

Улсын хилийг хамгаалах, хилийн аюулгүй байдлыг хангах дээрх хэрэгцээ шаардлага, бүс нутгийн нөхцөл байдал, Монгол Улсын дотоод улс төр, хилийн цагийн байдлаас үндэслэн хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог шинээр бий болгох, хилийн аюулгүй байдлын албаны үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар ажиллах шаардлага тавигдаж байна. Эдгээр үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тайлбарлах нь илүүц тул бүс нутгийн аюулгүй байдал, хилийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг шинэ шатанд гаргах, хилийн аюулгүй байдлын ажилтнуудыг сургах, бэлтгэх, техник технологийг сайжруулах, бэлэн байдал, ажиллагааны далайцыг эрчимжүүлэх гэх мэт олон талт арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна (Дашдаваа.Д, Ганболд.Ц, Муратхан.А, 2021, 2024).

Оперативын байгууламжийн тухай
ойлголт

Улсын хил хамгаалалтын оперативын байгууламжийг: Монгол Улсын хилийн тухай хуульд Улсын хил





ХИЛ СУДЛАЛ

хамгаалалт нь “Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг хэлнэ (хууль, 2017) гэж хуульчилсан. Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд олон хүчин зүйлүүд нөлөөлөх боловч энэхүү судалгааны ажилд хил хамгаалалтын байгууламжийг чухалчлан судласан билээ.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1.9-д “Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж” гэж хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий саад, мөр хянах зурвас, зам, гүүр, хянах цамхаг, холбоо, дохиолол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон бусад байгууламжийг хэлнэ (хууль, хилийн тухай хууль, 2017).

Манай Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хил хамгаалалтын дүрэмд хилийн отрядын хил хамгаалалтын байгууламж нь хүч хэрэгсэл, хил хамгаалалтын зааг, хилийн инженерийн байгууламж, дохиолол-хяналтын хэрэгслээс бүрдэнэ гэж тусгасан байна.

А.Хүч хэрэгсэл

-Бие бүрэлдэхүүн;

-Инженер, дохиолол-хяналтын хэрэгсэл;

-Мэдээлэл технологийн хэрэгсэл;

-Техник хэрэгсэл;

-Албаны амьтад;

-Хил хамгаалалтад туслах хүчин зэрэг хүч хэрэгслийг ашиглана гэж тусгасан.

Монгол Улсын хилийн тухай хуульд “Улсын хил хамгаалах байгууллага” гэж

Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбарыг; (хууль, хилийн тухай хууль, 2017) “Хилчин” гэж хилийн цэрэгт алба хааж байгаа цэргийн жинхэнэ алба хаагчийг; (хууль, хилийн тухай хууль, 2017) гэж тодорхойлсон байдаг. Тэгвэл улсын хил хамгаалалтыг газар орон дээр зохион байгуулах үүрэг хүлээдэг хилийн заставууд нь бүсийн онцлог, цагийн байдлаас шалтгаалан тэдний өдөр тутмын хийгдэж буй ажил, гүйцэтгэх үүрэг албаны ачаалал харилцан адилгүй байна.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1.9-д “Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж” гэж хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий саад, мөр хянах зурвас, зам, гүүр, хянах цамхаг, холбоо, дохиолол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон бусад байгууламжийг хэлнэ.

Б.Хилийн инженерийн байгууламж

Хил хамгаалалтын инженерийн байгууламжуудын түүхийг судлах явцад эхлээд хашаа, хана, хэрэм босгох зэргээр ордныхоо, хотынхоо, цаашдаа улсынхаа хилийг хамгаалж ирсэн нь тодорхой байдаг. Өөрөөр хэлбэл, хилийн хамгаалалт эхлээд эзэн хаанаа, дараа нь ордноо, тэгээд хотоо эцэст нь хилийнхээ заагийг хамгаалах хэлбэрээр хөгжиж иржээ.

Улсын хилээ төхөөрөмжилж, хаалт саад хана хэрэм босгох арга 1200-аад оны эхээр Оросод анх нэвтэрч зуунаас зуунд боловсронгуй болсоор улсын хилийн инженер техникийн хангалт болон төлөвшиж, хилийг инженер техникийн хэрэгслээр хамгаалах аргыг нөхцөлдүүлжээ. Одоо ч ач холбогдлоо алдаагүйгээр барахгүй ач холбогдол нь улам бүр өссөөр байна. Дэлхийн улс бүхэн тэр дундаа Монгол Улс хилийн шугамын дагуу техникийн төхөөрөмжлөлт хийхийг чухалд үздэг. Энэ дотроос инженерийн төхөөрөмжлөлт нь онцгой байр эзэлдэг. Улсын хилийн дагуу инженерийн

төхөөрөмж хийснээр улсын хил энд байна гэдгийг бүх нийтээр мэдэх, нөгөө талаар улсын хилийг дур мэдэн өөрчлөх, зөрчихгүй байх үүднээс хилийн шугамын дагуу инженерийн байгууламж, саад, хаалт барьж байгуулдаг. Энэ нь улсын хил манах үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн олон төрлийн арга хэмжээний цогц юм. Инженерийн байгууламжид хилийн тэмдэг, багана, хилийн дагуух мөр хяналтын зурвас, төрөл бүрийн саадууд, хяналтын байрууд, зам, харгуй, нисэх онгоц, нисдэг тэрэгний хөөрөх, буух талбай, усан хилийн хөнгөн хөлөг онгоцны зогсоол, худаг ус, хилийн манааны дулаацах байр, машин техник, радиолокацийн станцийн далдлагдсан байрууд зэрэг ордог. Хэрэв инженер-техникийн хангалт байхгүй бол улсын хил зөрчигчид задгайрч тэднийг барьж саатуулалгүй алдах аюултай. Тухайлбал улсын хилээр хууль бусаар нэвтэрсэн этгээдийг нутгийн гүнд хэдэн зуун километрийн зайд алдах эсвэл дотоодоос гарах зорилготой этгээдийг саатуулж чадалгүй гадагш алдах болно.

Тиймээс улсын хил хамгаалалтад инженерийн байгууламж ашиглахгүйгээр манах, хамгаалах боломжгүй бөгөөд хөрш болон бусад хөгжингүй орнууд цэрэг армийнхаа зэвсэглэл, техник-технологийг шинэчлэх, ашиглах боломжоо улам бүр нэмэгдүүлсээр байгаа билээ.

Инженерийн алба гэдэг нь ихэнх орнуудын зэвсэгт хүчинд байдаг, байлдааны ажиллагааг инженерийн талаар хангах, цэрэг /хүч/-ийг инженерийн хувьд бэлтгэх, тэдэнд инженерийн зэвсэглэлийн хэрэгслийн хангалт хийх, тэдгээрийн зөв ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан хангах үүрэг гүйцэтгэдэг тусгай алба юм. (газар, 2003)

Инженерийн байгууламж нь байлдаан /операци/-ы бүх төрлүүдэд газар орныг инженерийн хувьд төхөөрөмжлөх явцад байгуулагдана. Цэргийн бэхлэлт, цэргийн зам, гүүр, аэродром, хуурамч объектуудын макетууд багтана. Төмөр бетонон, мод шороон, хуягласан байж болно. Тэднийг ихэвчлэн задалж угсардаг бүтэцтэй хийцүүд ашиглан байгуулдаг.

1970-аад оны сүүлээс Монгол Улсын төр засгаас улсын хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд, манай улсын өмнөд хилийн ихэнх отряд инженерийн талаар төхөөрөмжлөгдөж, ЗХУ-ын буцалтгүй тусламжаар шинэ, шинэ техник хэрэгслүүд хил хамгаалалтад нэвтэрсэн нь, манай хилчдийг Зөвлөлтийн хил хамгаалалтын туршлагаас суралцан, эдгээр техник хэрэгслүүдийг яаж ашиглаж, ямар аргаар хилээ хамгаалж байгаатай танилцаж, тэднээс суралцах боломжийг бүрдүүлсэн байна.

Монгол Улсын хилийн хамгаалалтад:

- Мөр хянах зурвас
- Хориглон хамгаалалтын төхөөрөмж
- Хянах төхөөрөмж
- Инженерийн тэсэрдэггүй саад
- Хилийн зам, гүүр зэрэг инженерийн

төхөөрөмжүүд

- Дохиолох хэрэгсэл
- Радиотехникээр илрүүлэх хэрэгсэл
- Техникээр хянах хэрэгсэл
- Гэрлийн техник хэрэгсэл
- Хилийн шалгалтын техник хэрэгсэл
- Өнгөлөн далдлах хэрэгсэл зэрэг хил

хамгаалалтын техник хэрэгслүүд нэвтэрснийг илүү боловсронгуй болж, нягтрал, давтамжийг нь нэмэгдсэнээр улсын хил дээр гарах зөрчлийг өдөр, шөнө харгалзахгүй шуурхай илрүүлэн саатуулах боломж нэмэгдэнэ гэж тооцоолж байна.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын хилийн 26.2 хувийг хамарсан 2169.5 км урт өргөст торон хашааг ашиглаж байгаагийн дотор 49.2 хувь нь өмнөд хил дээр, 16.3 хувь нь умард чиглэлд байна. Өөрөөр хэлбэл улсын хилийн ихэнх хэсэгт ямар нэг инженерийн саад баригдаагүй гэсэн үг. Мөн хилийн дагуу өнгөрсөн хугацаанд 3526.6 км мөр шалгах зурвас ашиглаж байсан бол өнөөгийн байдлаар 1370.6 км буюу Монгол Улсын хилийн 16.6 хувийг хамардаг болж буурчээ. Улсын хилийн дагуу 73.0 хувьд нь мөр шалгах ийм зурвас татагдаагүй, одоогийн байгааг нь борнойдох зэргээр байнгын ашиглалтад байлгаж чадахгүй байна.





ХҮҮЛЬ САХИУЛАХҮЙ

Одоо улсын хил дээр 377 хянах байр байгаа ба нэг хянах байрт дунджаар 21.8 км хэсэг оногдож байгаа юм.

Хил хамгаалах байгууллага дахин байгуулагдсан үе болох 1967 оноос эхлэн хилийн заставын барилга байгууламжийн тоо 150, хөрөнгө оруулалтын хэмжээ 93, техникийн тоо 36 дахин нэмэгдсэн байна. Өмнөд хилийн дагуух заставт дунджаар 1-2 төмөр хянах цамхаг, 3400 км мөр хянах зурвас, 2200 км гаруй өргөс утсан хашаа, 36 км цахилгаан дохиоллын систем, 224 ширхэг кристалл багаж, прожекторын станц-34, радиолокацийн станц-17,

заставын тулгуурт байр-75, отрядын хориглолтын район-10, хилийн районд нийт замын сүлжээний урт 4932 км хүрч нийт уртаараа 581 км гүүрийг барьж байгуулан хил хамгаалалтын эрх ашигт нийцүүлэн ашиглаж байна (Д.Нямдорж, 2010) гэж доктор Д.Нямдорж өөрийнхөө судалгааны ажилд дурдсан байдаг.

Харамсалтай нь дээрх байгууламжуудаас өнөөдрийн байдлаар цөөн тооны хянах цамхаг, хэдхэн км мөр хянах зурвас, өргөст утсан хашаа үлдсэнийг эс тооцвол бараг байхгүй гэж хэлж болохоор байна.

д/д	Байгууламжийн нэр	Монгол-Хятадын хилд	Монгол-Оросын хилд	Үүнээс ашиглагдаж байгаа	Ашиглалтын хувь
1	Өргөст утсан хашаа	2318,6	578,2	2169,5	93,7
2	Мөр хянах зурвас	3379	147,6	1370,6	40,5
3	Хянах манааны байр	216	161	377	100,0
4	Хянах цамхаг	65	50	83	72,5
5	Дохиоллын систем	12	-	-	-
6	Модон болон төмөр бетон гүүр	15	23	36	94,7
7	Агаарын баганат шугам	2184,5	507,5	2692	100,0
8	Холбооны кабель шугам	140,863	18,88	160,7	99,0

Хүснэгт 1.Хил хамгаалах байгууллагад ашиглаж байгаа инженерийн байгууламж

Эх сурвалж: Судлаач нэгтгэв

Техникийн харуул, техникээр хил хамгаалахтай холбоотой бүх төхөөрөмжүүд, тийм төрлийн техник хэрэгслүүд, хилийн отрядуудад байсан инженерийн мэргэжлийн офицерууд, тусгай салаа, тухайн ангийн орон тооны бүтцээс үндсэндээ хасагдаж одоо хилийн отрядуудад энэ албыг мэргэжлийн бус офицерууд ёс төдий хавсран гүйцэтгэх болжээ.

Хилийн отрядуудад 2011 онд зэвсэг, техникийн албаны офицерууд (инженерийн албыг хавсран гүйцэтгэж байгаа)-ын дунд явуулсан судалгаанд нийт 27 офицер оролцсоноос мэргэжлийн чиглэлийн нэг ч хүнгүй, 2-3 жил ажиллаж байгаа хүн 15 хувь, бусад нь бүгд 1-2 жил ажиллаж байгаа гэсэн судалгааны дүгнэлт байдагаас инженерийн албаны ажил үүргийг талаар ямар ч мэдлэг, ойлголтгүй байгаа нь харагдаж байна.

В.Дохиолол-хяналтын хэрэгсэл

Монгол Улсын хилийн тухай хуульд “Улсын хил хамгаалалтын зориулалттай

инженер, техникийн байгууламж” гэж хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий саад, мөр хянах зурвас, зам, гүүр, хянах цамхаг, холбоо, дохиолол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон бусад байгууламж”-ийг хэлнэ гэж заасан байдаг.

Түүний нэг төрөл болох дохиолол хяналтын техник хэрэгслийн авч үзье.

Хяналтын техник хэрэгсэл, дохиоллын зориулалттай илрүүлэлтийн техник хэрэгслүүдээс мэдээлэл хүлээн авах, бүртгэх, цуглуулах нэгтгэн боловсруулж дүгнэлт хийх, хүлээн авч байгаа мэдээллийг операторт харуулах болон тухайн төхөөрөмж (дүрсийн камер, гэрэлтүүлгийн хэрэгсэл)-ийг алсаас удирдах, тэдгээрийн ажиллагааны хэвийн байдлыг хангах үүрэг бүхий нэгдмэл төхөөрөмжийг хэлнэ.

Хилийн отряд нь агаарын довтолгооноос хамгаалах цэргийн

салбаруудтай харилцан ажиллагаатай байж, өөрийн хариуцсан хэсэгт отряд, застав, харуул, манааны хүч хэрэгсэл болон хяналт, дохиоллын техник хэрэгслийг ашиглан агаар, газар, усны мандалд тасралтгүй хяналт зохиодог.

Хяналт нь хил хамгаалалтын болон цэргийн тагнуулын үндсэн аргуудын нэг мөн бөгөөд хилийн шугам, хил залгаа улсын нутаг дэвсгэр, өөрийн нутаг, агаарын орон зайд тасралтгүй ажиглалт зохиох замаар хилийн болон хил орчмын дэглэм зөрчихөөр бэлтгэж байгаа шинж тэмдгүүдийг илрүүлэх зорилгоор явагдана.

Манай улс, хил залгаа улсын хил орчмын нутаг дахь ажил, үйлдвэрлэл, хилийн ойролцоох хот, суурин, бусад анхаарал татаж буй объект, хил давсан зам, инженерийн төхөөрөмж, хяналт, дохиоллын байгууламжаар бүрэн халхлагдаагүй болон хяналтад өртдөггүй газруудад зөрчил гарч болзошгүй хэсэг, хариуцсан хэсгийн уулзварууд, гамшиг, аюулт үзэгдэл гарч байсан болон гарч болзошгүй газар, агаарын орон зай, хилийн гол, нуурын мандал дээр хөдөлгөөн үйлдэж байгаа бүх төрлийн нисэх, хөвөх хэрэгсэлд цэргийн хяналтыг зохион байгуулж, хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх ба хариуцсан хэсгийн газар орныг нарийн судлаж хянах байр, хяналтын техник хэрэгслүүдийн байрлалыг зөв сонгох,

дохиоллын техник хэрэгслийг зөв байршуулах, хяналт явуулах аргад бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах, хяналтын техник, дохиоллын хэрэгслийг чадварлаг ашиглах, өнгөлөн далдлалтын арга хэмжээг хатуу сахих, анхаарал татсан болон шинэ объектуудад хяналт тавих арга хэмжээг цогцоор авснаар хил хамгаалалтын үр дүн тодорхойлогдоно.

Г.Сэтгэл ханамжийн судалгааны талаар

Хил хамгаалах байгууллагын алба хаагчдаас хил хамгаалалтад ашиглаж буй орчин үеийн техник технологи, цахим хөгжүүлэлтийн талаарх сэтгэл ханамж, цаашид технологийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор хаалттай 12, нээлттэй 2 нийт 14 асуумж бүхий судалгааг анкетын аргаар авч, SPSS-21 судалгааны программаар тоон мэдээллийг боловсруулсан.

Судалгаанд баруун бүсийн 5, зүүн бүсийн 6, өмнөд бүсийн 6, хойд бүсийн 6, төвийн бүсийн 9 нийт 32 ангийн офицер 1395, ахлагч 1703, төрийн үйлчилгээний ажилтан 663, нийт **3761** алба хаагч хамрагдсан. Үүнд 63-80 насны 3, 42-62 насны 579, 29-41 насны 2135, 18-28 насны 1044 алба хаагч байгаагаас 62.5 хувь нь эрэгтэй, 37.4 хувь нь эмэгтэй алба хаагч байна.

Насны үечлэл	Офицер	Ахлагч	ТҮА	Эрэгтэй	Эмэгтэй	Хувь
Нийт	64-81	1		2	3	0.7%
	43-63	194	146	239	300	15.3%
	30-42	898	959	278	1352	903
	18-29	302	598	144	697	354
						27.7%

Хүснэгт 2, Судалгаанд хамрагдсан бүрэлдэхүүний насны үечлэл

Эх сурвалж: Судлаач нэгтгэв


Судалгаанд хамрагдсан бүрэлдэхүүний насны үечлэлийн байдлыг судалж үзэхэд 56.7 хувь нь 30-42 насны буюу Y үеийнхэн, 27.7 хувь нь 18-29 насны буюу Z үеийнхэн байгаа бол 15.3 хувь нь 43-63 насны буюу X үеийнхэн байна. Үүнээс харахад одоогийн байдлаар нийт ажиллагсдын талаас илүү хувийг 30-42 насны буюу Y үеийнхэн эзэлж байгаа боловч 18-29 насны буюу Z үеийнхэн 27.7

хувийг эзэлж байгаа нь хэдхэн жилийн дараа зонхилох хувийг бүрдүүлэх нь тодорхой юм. Тиймээс технологд суурилсан онцлог бүхий Z үеийн алба хаагчдаар хил хамгаалалтыг зохион байгуулахад орчин үеийн техник, технологийг албанд өргөнөөр ашигласанаар үзүүлэх үр дүн нь илүү байх юм.





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХУЙ



Хүснэгт 3, Судалгаанд хамрагдсан бүрэлдэхүүний Хил хамгаалах байгууллагад ажилласан байдал:

Эх сурвалж: Судлаач нэгтгэв

Судалгаанд хамрагдсан бүрэлдэхүүний 974 хүн буюу 25.8 хувь нь 1 жил хүртэл, 1422 хүн буюу 37.8 хувь нь 2-10 жил, 1176 хүн буюу 31.2 хувь нь 11-20 жил, 189 хүн буюу 5 хувь нь 21-ээс дээш жил ажилласан байна.

Дүгнэлт, санал

Хүн төрөлхтөн урьд хожид байгаагүй хувьсамтгай, тодорхойгүй, төвөгтэй, эргэлзээтэй орчинд амьдарч байна. Хиймэл оюун ухаан, техник технологийн шинэчлэлт, мэдээлэлд тулгуурласан дэвшилүүд нь урьд өмнө байгаагүй боломж бас шинэ эрсдэлийг бий болгож байна. Өөрчлөлтийн хурдац эрс эрчимжиж, байгаа энэ үед улс орон, хувь хүмүүст илүү холыг урьдчилан хардаг, шинэ нөхцөл байдалд хурдтай дасан зохицож, холбогдох шийдвэрүүдийг хурдан шуурхай гаргах чадвартай байхыг шаардах болсон.

Дэлхийн улс оронуудын геополитикийн өрсөлдөөн эрчимжиж, олон туйлт дэлхийн дэг журамд шилжих явцад, олон улсын цэрэг-стратегийн хурцадмал байдал үүсэж болох нөхцөлүүд нэмэгдсээр байна.

Аюулгүй байдлын гадаад орчны нөхцөл байдал болон цэрэг-стратег, байлдааны ажиллагааны шинж чанарт орж буй өөрчлөлтүүд нь шинэ сорилтыг бий болгож, аюулгүй байдал, батлан хамгаалах

асуудал, хилийн аюулгүй байдлыг хангах талаар шинэ нөхцөл үүсэж байна.

Орчин үеийн цэргийн ирээдүйн чиг хандлага нь хөнөөх чадвар өндөр, олон төрлийн тулалдааны талбарт үүрэг гүйцэтгэх чадвартай дрон, хиймэл оюун ухаан, мэдээллийн технологид суурилсан зэвсэглэл, техник, агаарын болон алсын тусгалтай зэвсэглэлийг хөгжүүлэх, цэргийн зэвсэглэлд нэвтрүүлэхийг ихэд анхаарах болоод байгаа энэ үед бид цэрэг-стратегийн орчинд болж байгаа хувьсал, өөрчлөлт, ирээдүйн хандлагыг сайн мэдэрч, хилийн аюулгүй байдлыг хангахад хил хамгаалалтын оперативын байгууламжаа олон улсын зэвсэгт хүчний мэргэжлийн армийн жишгээр хөгжүүлэх нь нэн чухал асуудал болоод байна.

Тиймээс бид бүс нутгийн хил хамгаалалтын оперативын байгууламжаа нэмэгдүүлэхдээ хилийн инженерийн байгууламж, дохиолол хяналтын хэрэгслээ хөгжүүлэх, хил хамгаалалтад орчин үеийн техник технологийг ашиглах замаар хүний орон зайг багасгаж, техникийн дэвшлийг ашиглахыг чухалчлах шаардлагатай юм.

Чичиргээ мэдрэгч бүхий шилэн кабелийн дохиоллын системийг “Тагнуулын Ерөнхий Газар”-аас мэргэжлийн баг томилон шалгуулж цаашид үндэсний компаниудтай хамтран

хөгжүүлэлт хийж Улсын Хил хамгаалалт, онцгой объектын хамгаалалтад нэвтрүүлэх.

Эх сурвалжийн жагсаалт

- Дашдаваа.Д, Ганболд.Ц, Муратхан.А. (2021, 2024). *Хилийн аюулгүй байдал*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- н.наранжамц. (2024). *бүс нутгийн хил хамгаалалт*. Улаанбаатар: улаанбаатар принт.
- Наранжамц. Н. (2017). Бүс нутаг ба хилийн аюулгүй байдал. *Хил шинжлэл*, 35.
- Наранжамц.Н. (2012, 2024). *Бүс нутаг-Хил хамгаалалтын үзэл баримтлал*. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг.

Наранжамц.Н. (2012, 2024). *Бүс нутаг-Хил хамгаалалтын үзэл баримтлал*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Наранжамц.Н. (2017). Монголын хил судлалын академи. *Бүс нутаг ба хилийн аюулгүй байдал*, 38.

Наранжамц.Н. (2017). хил шинжлэл. *бүс нутаг ба хилийн аюулгүй байдал*, 36.

Наранжамц.Н. (2017). хил шинжлэл. *бүс нутаг ба хилийн аюулгүй байдал*, 36.

Наранжамц.Н. (2024). *бүс нутаг-Хил хамгаалалтын үзэл баримтлал*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

УИХ. (2017). Монгол Улсын хилийн тухай хууль. *төрийн мэдээлэл*, 1.

УИХ. (2017). Монгол Улсын Хилийн тухай хууль. *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 1.



МОНГОЛ УЛСЫН
ХИЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬ